## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2026/004/НА-СТА-ТШЗ


| | | |
|---|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn | Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх | |
| | Утас:7036-3040 | Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn |
| Сүхбаатар сум | Ахлах аудитор: | Ц.Отгонбаяр |
| 2026 он | Утас: 7036-3036 | Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn |
| | Аудитор: | Ц.Уртнасан |
| | Утас: 7036-2442 | Цахим хаяг: urtaa6969@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

____________ № ____________

танай ____________-ны № ____________-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН
БУГАНТ ТОСГОНЫ ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Х.ДАВААЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус сургууль нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 26,619.9 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан болон барилгын их засварыг капиталжуулсан, Боловсролын ерөнхий газраас 3,011.4 мянган төгрөгийн самбар, ном сурах бичиг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй  нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн

хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн тайлант онд 5 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр 92.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БАТМӨНХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/төгрөгөөр/*

| Данс-ны код | Дансны нэр, төрөл | 1. Эхний үлдэгдэл | 2. Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 240,804,317.74 | 139,083,497.82 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 186,616,982.88 | 83,970,574.98 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 186,616,982.88 | 83,970,574.98 |
| 31210 | Төгрөг | 186,616,982.88 | 83,970,574.98 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 186,616,982.88 | 83,970,574.98 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 54,187,334.86 | 55,112,922.84 |
| 35400 | Хангамжийн материал | 54,187,334.86 | 55,112,922.84 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,044,700.00 | 3,044,700.00 |
| 35460 | Хүнсний материал | - | 122,850.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 51,142,634.86 | 51,945,372.84 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,116,872,676.55 | 985,948,838.52 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,116,872,676.55 | 985,948,838.52 |
| 39200 | Биет хөрөнгө | 1,084,592,076.55 | 953,668,238.52 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 613,151,801.20 | 632,651,801.20 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -132,204,041.91 | -157,843,371.40 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 14,562,500.00 | 14,562,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -10,517,361.14 | -14,562,500.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 469,806,497.49 | 476,926,397.49 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -84,774,341.78 | -190,551,467.59 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 162,957,599.06 | 164,357,599.06 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -42,274,918.26 | -66,814,623.95 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,094,500.00 | 5,094,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,674,621.22 | -4,228,454.80 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 53,843,324.00 | 53,843,324.00 |
| 39217 | Ном | 38,621,139.11 | 40,232,534.51 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 32,280,600.00 | 32,280,600.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,280,600.00 | 32,280,600.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 1,357,676,994.29 | 1,125,032,336.34 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 78,901,700.00 | 53,608,400.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 78,901,700.00 | 53,608,400.00 |
| 41300 | Өглөг | 78,901,700.00 | 53,608,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 41360 | Бусад өглөг | 78,901,700.00 | 53,608,400.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 78,901,700.00 | 53,608,400.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,278,775,294.29 | 1,071,423,936.34 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,278,775,294.29 | 1,071,423,936.34 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 335,538,988.20 | 335,538,988.20 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 335,538,988.20 | 335,538,988.20 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | -27,247,127.25 | -234,598,485.20 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -167,820,448.82 | -27,247,127.25 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 140,573,321.57 | -207,351,357.95 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 970,483,433.34 | 970,483,433.34 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 1,357,676,994.29 | 1,125,032,336.34 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

| Данс-ны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 1,845,284,260.03 | 2,095,812,669.30 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 161,245,647.70 | 14,986,102.90 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 161,245,647.70 | 14,986,102.90 |
| 120009 | Бусад орлого | 10,000,000.00 | 2,235,980.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 140,913,548.30 | 3,011,395.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 10,332,099.40 | 9,738,727.90 |
| 122 | Тусламжийн орлого | - | 1,796,381,500.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 1,796,381,500.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 1,465,764,800.00 | 1,796,381,500.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | 1,465,764,800.00 | 1,796,381,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,684,038,612.33 | 2,080,826,566.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,465,764,800.00 | 1,796,381,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,465,764,800.00 | 1,796,381,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 218,273,812.33 | 284,445,066.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 218,273,812.33 | 284,445,066.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,704,710,938.46 | 2,303,164,027.25 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,704,710,938.00 | 2,303,164,027.25 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,631,818,638.46 | 2,200,789,497.11 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,168,311,479.15 | 1,509,068,795.54 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 716,507,620.57 | 902,947,573.79 |
| 210102 | Нэмэгдэл | 392,845,441.38 | 496,757,111.75 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 39,340,000.00 |
| 210104 | Урамшуулал | 58,958,417.20 | 70,024,110.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 147,441,619.19 | 186,851,350.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 100,768,041.39 | 127,499,503.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 11,802,912.40 | 15,177,275.46 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 5,883,469.47 | 7,534,831.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 5,785,148.68 | 7,288,100.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 23,202,047.25 | 29,351,639.52 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 210,381,212.33 | 216,372,565.86 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,375,892.33 | 14,971,245.86 |
| 210302 | Түлш, халаалт | 167,300,320.00 | 167,300,320.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 33,705,000.00 | 34,101,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,872,838.70 | 5,756,389.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 5,756,389.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,872,838.70 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,892,600.00 | 43,722,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,892,600.00 | 43,722,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 17,287,565.79 | 24,117,899.96 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 17,287,565.79 | 24,117,899.96 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 75,631,323.30 | 214,899,996.35 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,544,500.00 | 44,909,760.92 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,629,400.00 | 9,435,102.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 20,457,423.30 | 160,555,133.43 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 72,892,300.00 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 72,892,300.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 65,563,300.00 | 102,374,530.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,329,000.00 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 140,573,321.57 | - 207,351,357.95 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 140,573,321.57 | - 207,351,357.95 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 1,694,038,612.3 | 2,083,062,546.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 10,000,000.0 | 2,235,980.0 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 10,000,000.0 | 2,235,980.0 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 2,235,980.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,235,980.0 |
| 120009 | Бусад орлого | 10,000,000.0 | - |
| 122 | Тусламжийн орлого | - | 1,796,381,500.0 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 1,796,381,500.0 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 1,796,381,500.0 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 1,796,381,500.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,684,038,612.3 | 2,080,826,566.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,465,764,800.0 | 1,796,381,500.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,465,764,800.0 | 1,796,381,500.0 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 218,273,812.3 | 284,445,066.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 218,273,812.3 | 284,445,066.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,693,042,876.5 | 2,178,589,053.9 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,693,042,876.5 | 2,178,589,053.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,620,096,976.5 | 2,076,091,673.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,168,311,479.2 | 1,509,068,795.5 |
| 210101 | Үндсэн цалин | 716,507,620.6 | 889,102,709.3 |
| 210102 | Нэмэгдэл | 392,845,441.4 | 510,601,976.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 39,340,000.0 |
| 210104 | Урамшуулал | 58,958,417.2 | 70,024,110.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 147,441,619.2 | 186,851,350.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 100,768,041.4 | 127,499,503.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 11,802,912.4 | 15,177,275.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 5,883,469.5 | 7,534,831.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 5,785,148.7 | 7,288,100.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 23,202,047.3 | 29,351,639.5 |

| | | | |
|---|---|---|---|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 210,381,212.3 | 216,372,565.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,375,892.3 | 14,971,245.9 |
| 210302 | Түлш, халаалт | 167,300,320.0 | 167,300,320.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 33,705,000.0 | 34,101,000.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,892,600.0 | 68,072,500.0 |
| 210604 | Урсгал засвар | 7,892,600.0 | 68,072,500.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 17,287,565.8 | 30,617,900.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 17,287,565.8 | 30,617,900.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 68,782,500.0 | 65,108,562.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,153,100.0 | 55,316,462.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,629,400.0 | 9,792,100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 72,945,900.0 | 102,497,380.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 72,945,900.0 | 102,497,380.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 65,563,300.0 | 102,497,380.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,382,600.0 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 995,735.9 | - 95,526,507.9 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 32,847,995.0 | 7,119,900.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 32,847,995.0 | 7,119,900.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 32,847,995.0 | 7,119,900.0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 32,847,995.0 | 7,119,900.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | - 32,847,995.0 | - 7,119,900.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | - 31,852,259.1 | - 102,646,407.9 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 218,469,242.0 | 186,616,982.9 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 186,616,982.9 | 83,970,575.0 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| Данс-ны код | Дансны нэр, төрөл | 1.1 Засгийн газрын оруулсан капитал | 1.2 Дахин үнэлгээний нөөц | 1.3 Хуримтлагдсан үр дүн | 1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 335,538,988.2 | 970,483,433.3 | -167,820,448.8 | 1,138,201,972.7 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 335,538,988.2 | 970,483,433.3 | -167,820,448.8 | 1,138,201,972.7 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 140,573,321.6 | 140,573,321.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 335,538,988.2 | 970,483,433.3 | -27,247,127.3 | 1,278,775,294.3 |
| 11 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 335,538,988.2 | 970,483,433.3 | -27,247,127.3 | 1,278,775,294.3 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 335,538,988.2 | 970,483,433.3 | -27,247,127.3 | 1,278,775,294.3 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | -207,351,358.0 | -207,351,358.0 |
| 20 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 335,538,988.2 | 970,483,433.3 | -234,598,485.2 | 1,071,423,936.3 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл | 12. Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 2,109,764,400.0 | 2,083,062,546.0 | 26,701,854.0 | 98.7 |
| 12 | Татварын бус орлого | 2,109,764,400.0 | 2,083,062,546.0 | 26,701,854.0 | 98.7 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,201,100.0 | 2,235,980.0 | -34,880.0 | 101.6 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 2,201,100.0 | 2,235,980.0 | -34,880.0 | 101.6 |
| 122 | Тусламжийн орлого | 1,801,475,500.0 | 1,796,381,500.0 | 5,094,000.0 | 99.7 |
| 122005 | Улсын Төсвөөс санхүүжих | 1,801,475,500.0 | 1,796,381,500.0 | 5,094,000.0 | 99.7 |
| 122005 | Орон нутгийн Төсвөөс санхүүжих | 306,087,800.0 | 284,445,065.9 | 21,642,734.1 | 92.9 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,294,707,400.0 | 2,185,708,954.0 | 108,998,446.0 | 95.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,294,707,400.0 | 2,185,708,954.0 | 108,998,446.0 | 95.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,880,539,900.0 | 1,798,766,507.9 | 81,773,392.1 | 95.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,579,420,700.0 | 1,509,068,795.5 | 70,351,904.5 | 95.5 |
| 210101 | Үндсэн цалин | 973,342,700.0 | 889,102,709.3 | 84,239,990.7 | 91.3 |
| 210102 | Нэмэгдэл | 554,924,500.0 | 510,601,976.2 | 44,322,523.8 | 92.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 39,340,000.0 | -39,340,000.0 | 0.0 |
| 210104 | Урамшуулал | 51,153,500.0 | 70,024,110.0 | -18,870,610.0 | 136.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 197,720,700.0 | 186,851,350.4 | 10,869,349.6 | 94.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 134,450,100.0 | 127,499,503.4 | 6,950,596.6 | 94.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,817,700.0 | 15,177,275.5 | 640,424.5 | 96.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,908,800.0 | 7,534,831.8 | 373,968.2 | 95.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,908,800.0 | 7,288,100.2 | 620,699.8 | 92.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,635,300.0 | 29,351,639.5 | 2,283,660.5 | 92.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 238,015,300.0 | 216,372,565.9 | 21,642,734.1 | 90.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 23,008,400.0 | 14,971,245.9 | 8,037,154.1 | 65.1 |
| 210302 | Түлш, халаалт | 181,301,900.0 | 167,300,320.0 | 14,001,580.0 | 92.3 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 33,705,000.0 | 34,101,000.0 | -396,000.0 | 101.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 68,072,500.0 | 68,072,500.0 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 68,072,500.0 | 68,072,500.0 | - | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 30,974,000.0 | 30,617,900.0 | 356,100.0 | 98.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 30,974,000.0 | 30,617,900.0 | 356,100.0 | 98.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 72,424,500.0 | 72,228,462.0 | 196,038.0 | 99.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,632,400.0 | 62,436,362.0 | 196,038.0 | 99.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,792,100.0 | 9,792,100.0 | - | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 108,079,700.0 | 102,497,380.0 | 5,582,320.0 | 94.8 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 108,079,700.0 | 102,497,380.0 | 5,582,320.0 | 94.8 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 108,079,700.0 | 102,497,380.0 | 5,582,320.0 | 94.8 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | -184,943,000.0 | -102,646,407.9 | -82,296,592.1 | 55.5 |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 184,943,000.0 | 102,646,407.9 | 82,296,592.1 | 55.5 |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 184,943,000.0 | 102,646,407.9 | 82,296,592.1 | 55.5 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 186,616,982.9 | -186,616,982.9 | 0.0 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 83,970,575.0 | -83,970,575.0 | 0.0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **881.7** мянган төгрөгийн дараах алдааг залруулллаа.Үүнд:

- Байгууллагын ГҮ-ний урамшууллаас суутгасан суутгалын 881.7 мянган төгрөгийг СЭ.Ерөө УТХ-ын буцаан олголт дансанд шилжүүлж татварын тайланд өр төлбөр үүсгэсэн алдааг залруулсан.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", *УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга"-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв*

*толилуулах ёстой...",* гэсэн заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлангийн *"Үнэлгээ ба хуваарилалт"* батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 86,576.9 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 1,400.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 85,176.9 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,400.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 15,647.9 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

**3.1.1** Ээлжийн жижүүр ажилтай 4 албан хаагчид ээлжинд гараагүй өдрүүдэд хоолны хөнгөлөлтийг тооцон 1,400.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь "*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ*", 20.2.5 дахь "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нормативт зардалтай холбоотой асуудал***

1.1 Илрүүлэлт: Хүүхдийн хоолны хүнсний материалыг олгохдоо насны ялгавартай нормативын дагуу тооцож олгоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 сарын 2 өдрийн А/166 / А/559/ 222 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ"-г тогтоосон тушаалыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "*Нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Хүүхдийн хоолны хүнсний материалыг батлагдсан нормативын дагуу насны ялгавартайгаар тооцож олгох зөвлөмж хүргүүллээ.

***2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:***

*2.1 Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй тайлант оны эцэст ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа нийт 85,176.9 мянган төгрөгийн анхны үнэтэй 187 нэр төрлийн

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дахь *" ... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*", УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн 13 (б)-д *"... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ..."* гэсэн заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "*Үнэлгээ ба хуваарилалт*" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, актлах саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5[2] дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[2] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын ГҮ-ний урамшууллаас суутгасан суутгалын УТХ-ын буцаан олголт дансанд шилжүүлж. татварын тайланд өр төлбөр үүсгэсэн | 1 | 881.7 | | | 1 | 881.7 | 1 | 881.7 | | | | |
| **Дүн** | **1** | 881.7 | | | **1** | 881.7 | **1** | 881.7 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаал-тны тоо | Тоо | Дүн |
| Хүүхдийн хоолны хүнсний материалыг нормативын дагуу насны ялгавартай тооцож олгоогүй. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй. | 1 | 85,176.9 | | | | | 1 | 85,176.9 | | | | |
| **Дүн** | **2** | 85,176.9 | | | | | **2** | 85,176.9 | | | | |

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | Аудитад хамрагдах | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | | | | | | | | |